**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 05 сарын 29 өдөр Дугаар А/13 Улаанбаатар хот

Дархлаажуулалтын 10 хоногийн
үйл ажиллагааны зохион байгуулалтанд
зарцуулах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, Халдварт Өвчин Судлалын үндэсний төвийн ерөнхий захиралын 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн "Дархлаажуулалтын 10 хоногийн үйл ажилланаанд дэмжлэг үзүүлэх тухай" А/100 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Улаанбурхан өвчнөөс хамтдаа сэргийлье" уриан дор зохион байгуулж байгаа дархлаажуулалтын ажлын талаарх иргэдэд мэдээллийг цаг алдалгүй хүргэх зорилгоор дархлаажуулалтыг зохион байгуулж байгаа ажлын хэсгийн гишүүдэд ДЭМБ-ын санхүүжилтаар ирсэн утасны нэгжийг олгож холбогдох тайланг цаг хугацаанд тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Дашдэлэг), нарийн бичгийн дарга (О.Удвал) нарт үүрэг болгосугай.

2. НҮБ-ийн Хүүхдийн сангийн санхүүжилтаас олгосон тээврийн зардлыг нэмэлт дархлаажуулалтын 10 хоногт вакцин татах, төвөөс алслагдсан өртөө зөрлөг, хөдөөгийн малчид, иргэдийн хүүхдүүдийг дархлаажуулалтанд хамруулах явуулын багийн үйл ажиллагаа, дархлаажуулалтын үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулж холбогдох тайлан, санхүүгийн баримтыг бүрдүүлэн цаг хугацаанд нь тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Дашдэлэг), нарийн бичгийн дарга (О.Удвал) нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Чанарын менежер (Д.Дашдэлэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА Х.ГАНБАТ